

# “БОРНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 15-ны өдөр

№ 21/1

Борнуур сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус

Хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын 2.1, 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Борнуур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2021 оны 11-р сарын 26-ны өдрийн 11 цагт Төв аймгийн Борнуур сумын Соёлын төвд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 11-р сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

Үүнд:

1. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
2. Ноогдол ашиг тараахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэр
3. 2021 онд үйл ажиллагааны төлөвлөгөө биелэлийг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2021 оны 10 сарын 18-ны өдөр, 2021 оны 11 сарын 4-ны өдрүүдэд хурлын зар түгээх СЗХ-ны журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2021 оны 11 сарын 25-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар Хавсралт 1-р Хурлын дэг, бичиг баримтын жагсаалтыг Хавсралт 2-р, саналын хуудсын Хавсралт 3-р, зарын загварыг хавсралт-4 р тус тус баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалтай өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан болохыг дурьдсугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг нотлох баримтыг үндэслэн компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах комиссийн даргаар Г.Мөнхбат, гишүүнээр Н.Бямбажаргал, тооллогын комиссийн даргаар Б.Нацагдорж, гишүүнээр Т.Нямдолгор нарыг тус тус томилсугай.

10. “Борнуур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг “Санхүүгийн Зохицуулах Хороо”, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТДОРЖ